

ГАРЧИГ

НЭГ. ТОВЧ ТАНИЛЦУУЛГА -----	4
1.1 Төслийн товч тодорхойлолт -----	5
$Cl_2 + 2NaOH = NaCl + NaClO + H_2O$ -----	8
ХОЁР. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ -----	10
2.1 Төслийн гол болон болзошгүй нөлөөлөл -----	10
2.1.1 Шууд нөлөөлөл -----	10
2.1.2 Шууд бус нөлөөлөл -----	10
2.2 Нөлөөллийн үргэлжлэх хугацаа -----	10
2.3 Нөлөөллийн эрчим -----	11
2.4 Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээ -----	11
2.5 Байгаль орчны менежментийн төлөвлөгөө -----	11
ГУРАВ. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ -----	11
3.1 Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө -----	12
3.2 Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө -----	16
3.3 Эрсдлийн менежментийн төлөвлөгөө -----	17
3.5 Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр -----	20
3.6 Байгаль орчны менежмент төлөвлөгөө ба түүний хэрэгжилтийг оролцогч, сонирхогч талуудад тайлагнах, хэлэлцүүлэх хуваарь. -----	22
3.7 Байгаль орчны менежмент төлөвлөгөөнд тусгагдсан нийт зардал -----	23

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг.1 Уурын автоклавт-----	6
Зураг.2 Ус шүүгч -----	6
Зураг.3 Компрессор-----	7
Зураг.4 Усан буу -----	7
Зураг. 5 Шатаах зуух-----	7
Зураг. 6 Аюултай хог хаягдал шатаах зуух -----	8
Зураг. 7 Хлоргүйжүүлэх төхөөрөмжийн фото зураг-----	8

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Төслийн товч танилцуулга -----	4
Хүснэгт 2. Төсөлд ашиглагдаж буй техник тоног төхөөрөмжийн жагсаалт-----	5
Хүснэгт 3. Ажиллах хүчний мэдээлэл -----	8
Хүснэгт 4. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний нийт зардал ----	13
Хүснэгт 5. Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө-----	16
Хүснэгт 6. Эрсдэлийн менежментийн төлөвлөгөө -----	17
Хүснэгт 7. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний нийт зардал -----	19
Хүснэгт 8. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн нийт зардал -----	20
Хүснэгт 9. БОМТөлөвлөгөөг тайлагнах хуваарь -----	22
Хүснэгт 10. 2024 онд байгаль орчин хамгаалах чиглэлээр хийгдэх ажлын нийт зардал ---	23

НЭГ. ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Хүснэгт 1. Төслийн товч танилцуулга

д/д	Мэдээллийн төрөл	Мэдээлэл оруулах багана
1	2	3
1.1	1. Төсөл хэрэгжүүлэгч аж ахуйн нэгжийн нэр	“Элемент” ХХК
	2. Аж ахуйн нэгжийн улсын бүртгэлийн дугаар	9011082081
	3. Аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны чиглэл	ЭМБ-ын аюултай эрсдэлтэй хог хаягдал цуглуулах, тээвэрлэх, ариутгаж халдваргүйжүүлэн булах үйлдвэр
	4. Аж ахуйн нэгжийн харьяаллын хаяг	УБ хот Налайх дүүрэг 3-р хороо Хүчилтөрөгчийн гудамж
	5. Захирлын нэр, утас, цахим шуудангийн хаяг	Ерөнхий захирал З.Баярсайхан Утас: 99193790 Цахим хаяг: info@element.mn
	6. Холбогдох мэргэжилтний нэр, утас, цахим шуудангийн хаяг	Ерөнхий менежер Б.Ундармаа Утас: 8810-3666 Цахим хаяг: undarmaab@element.mn
1.2	1. Төслийн нэр	Эрүүл мэндийн байгууллагын аюултай хог хаягдал боловсруулах төв
	2. Төслийн харьяаллын байршил	Улаанбаатар хот, Налайх дүүрэг 3-р хороо
	3. Төслийн ангилал	Жижиг дунд үйлдвэр
	4. Төсөл эхэлсэн огноо	2018 он
	5. Төсөл хэрэгжих хугацаа	Хугацаагүй
	6. Үйлдвэрийг хүлээж авсан улсын комиссын дүгнэлт	2020 оны 02-р сарын 10-ны өдөр тус байгууламжийн эмнэлгийн аюултай хог хаягдал боловсруулах үйлдвэр, агуулахын зориулалттай барилга байгууламжийг улсын комисс хүлээн авсан. Хүлээн аван комиссын дүгнэлт 2020 оны 4-р сарын 15-ны өдрийн 2020/194 тоот дүгнэлтээр баталгаажсан.
	7. ТЭЗҮ баталсан огноо	2019 он

1.1 Төслийн товч тодорхойлолт

Улаанбаатар хотын хэмжээнд хагас жил тутамд 28000 кг эмгэг хог хаягдал, 2000кг химийн бодис, урвалж, 19000 кг эмийн хог хаягдал, 78000кг хурц үзүүр ирмэгтэй хаягдал, ойр орчмын ЭМБ-аас 32000кг нийт 154000кг хог хаягдал хүлээн авч устгах хүчин чадалтай. Эмнэлгийн хог хаягдлыг уурын автоклавт халдваргүйжүүлэн аюулгүй болгосны дараа овор хэмжээг багасгах зорилгоор бутлагчаар буталж ландфиллдэж устгана.

Хүснэгт 2. Төсөлд ашиглагдаж буй техник тоног төхөөрөмжийн жагсаалт

№	Машин механизм, тоног төхөөрөмжийн нэр	Марк	Тоо ширхэг
1	2	3	4
1	Уурын автоклавт	-	2
2	Ус шүүгч	-	1
3	Компрессор	OTS-550x2	1
4	Усан буу	SK-280	1
5	Эксковатор	Cat	1
6	Өөрөө буулгагч Кантер машин	Caterpillar	2
7	Тээвэрлэлтийн машин	Titan	8
8	CAT D3 бульдозер	Cat	1
9	Шатаах зуух	A6000	1
10	Аюултай хог хаягдал шатаах зуух	2ST	1
Нийт			19

Автоклавын систем нь 139⁰C температурт ариутгал хийнэ. Үндсэн үзүүлэлт нь

- Хүчдэл: 220-380V
- Эрчим хүчний зарцуулалт: 0.85 Кв
- Уурын багтаамж: 1.5m³
- Давтамж: 50

- Төхөөрөмжийн жин: 5000кг



Зураг.1 Уурын автоклавт

Ус шүүгч нь ариутгал хийх усыг шүүж хатуулгыг багасган автоклавын шугам хоолойн хана бохирдохоос хамгаалах үүрэгтэй Здамжилгат усан шүүлтүүр.

Үндсэн үзүүлэлт нь

- Хүчдэл: 220V
- Эрчим хүчний зарцуулалт: 1.5 Кв
- Төхөөрөмжийн жин: 75кг



Зураг.2 Ус шүүгч

Хийн компрессор нь Автоклавын хийн хаалт, хавхлагыг нээх, хаахад шаардлагатай хийн даралтыг үүсгэж хийн хоолойг байнгын даралттай хийгээр дүүргэх ажиллагааг хангаж ажиллана.

- Хүчдэл: 220V
- Төхөөрөмжийн жин: 52 кг
- Хүчин чадал: 0.7мПа, 80L/min



Зураг.3 Компрессор

Үйлдвэрийн гадна болон орчин, тээврийн хэрэгслийн гадна болон тодор хэсгийн цэвэрлэгээ үйлчилгээг

- Хүчдэл: 220V
- Цахилгааны зарцуулалт: 50Hz
- Хүчин чадал: 9.8L/min
- Усны даралт: 1-6Мра



Зураг.4 Усан буу

Эмгэг хог хаягдал шатаах зуух

Тус шатаах зуух нь эмгэг, мал амьтны сэг зэмийг шатаах зориулалтын зуух бөгөөд өдөрт 1-3 тонн хог хаягдал шатаах хүчин чадал бүхий зориулалтын зуух юм.

- Үйлдвэрлэсэн улс: Англи улс
- Үйлдвэрлэсэн огноо: 2013 он
- Нийт жин: 5.5тн
- Шатах температур: 800-1200°C
- Шатаах хурд: 45 Кг/цаг
- Нэг удаа шатаах хаягдлын багтаамж: 750 кг
- Хүчин чадал /1 цагт/: 120-140 кг
- Өргөн: 910мм
- Өндөр: 4400мм
- Амны хаалт: 53x69мм
- Ханын зузаан / түлш хадгалах сав/: 4.9мм
- Их биеийн зузаан: 4.1-4.2мм



Зураг. 5 Шатаах зуух

Аюултай хог хаягдал шатаах зуух

Энэхүү шатаах зуух нь ротари системтэй цельсийн 800-1200 градуст бүх төрлийн хог хаягдлыг шатаана. Шатаалтаас үүссэн утааг 2 давхар усан шүүлтүүр, цахилгаан соронзон төхөөрөмж, яндангийн шүүлтүүр гэсэн дамжлагаар шүүнэ. Шатаах зуухны нийт урт 30м, хоногт 25-30тн хог хаягдал шатаах хүчин чадалтай.


- Үйлдвэрлэсэн улс: Хятад улс, Тайвань
- Технологи: Япон улсад боловсруулсан зураг төслөөр үйлдвэрлэсэн
- Үйлдвэрлэсэн огноо: 2020 он
- Шатах температур: 1-р шатаах камер 650-800, 2-р шатаах камер 800-1200°C
- Шатаах хурд: 1200-1500 Кг/цаг
- Нэг удаа шатаах хаягдлын багтаамж: 15м³
- Хүчин чадал /1 цагт/: 1.2-1.5тн
- Урт: 32м
- Өндөр: 8м
- Ханын зузаан / түлш хадгалах сав/: 4.9мм



Зураг. 6 Аюултай хог хаягдал шатаах зуух

Хлорын хий саармагжуулах тоног төхөөрөмж

Төхөөрөмжийн ажиллах зарчим нь хаягдсан хлорын хийг химийн урвалаар шингээж, хлорын саванд байгаа хлорын хийг цэвэрлэх.



Зураг. 7 Хлоргүйжүүлэх төхөөрөмжийн фото зураг

Хүснэгт 3. Ажиллах хүчний мэдээлэл

№	Албан тушаал	Орон тоо
0	1	2
Захиргааны хэлтэс		
1	Ерөнхий захирал	1
2	Санхүү хариуцсан захирал	1
3	Ерөнхий нягтлан бодогч, Үйлдвэрлэл эрхэлсэн дарга	1
4	Ерөнхий менежер, Хүний нөөц	1
5	Санхүүгийн алба	2
Ариутгал халдваргүйжүүлэлтийн тасаг		
1	Эрүүл ахуйч	1
2	Автоклавч	2
3	Угаагч	2
4	Бутлагч	1
Тээвэрлэлтийн алба		
1	Тээвэрлэлтийн албаны дарга	1

*Нийслэлийн Налайх дүүргийн 3-р хорооны нутагт орших “Элемент” ХХК-ийн
 “Аюултай хог хаягдал тээвэрлэх, цуглуулах, боловсруулах, устгах хими технологийн үйлдвэр”
 –ийн төслийн 2024 онд хэрэгжүүлэх Байгаль орчны менежментийн төлөвлөгөө*

№	Албан тушаал	Орон тоо
0	1	2
2	Жолооч	8
3	Техникч	7
4	Лодер оператори	1
5		
Инженер технкийн алба		
1	Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн ажилтан	1
2	Тоног төхөөрөмжийн инженер	3
3	Химич	3
4	Цахилгаанчин	1
5	Гагнуурчин	3
6	Туслах ажилтан	6
7	Харуул	3
Нийт		49

ХОЁР. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

2.1 Төслийн гол болон болзошгүй нөлөөлөл

Төслийн үйл ажиллагаанаас хүрээлэн буй орчинд учирч болзошгүй нөлөөллийг тогтоохдоо байгаль орчны суурь нөхцөл, дүгнэлт, урьд өмнө хийгдсэн байгаль, нийгэм, эдийн засгийн холбогдолтой судалгааны материалууд, судалгаа явуулсан мэргэжлийн экспертүүдийн дүгнэлтүүдийг үндэслэн тодорхойлоход сөрөг нөлөөлөлд өртөгдөх байгалийн үндсэн тусгагдахуун нь хөрс, газрын гадарга, ургамал, амьтан байна.

Төслийн үйл ажиллагаанаас байгаль орчны төлөв байдалд үзүүлж болзошгүй болон гол сөрөг нөлөөллийг тогтоох зорилгоор шинжээчдийн хэсэг газар дээр нь очиж, төслийн хэрэгжилтийн байдал болон орчны байдалтай танилцаж холбогдох судалгааг мөн хийсэн болно.

Төслийн болзошгүй нөлөөллийг тогтоохдоо магадлан жагсаах аргыг ашиглаж, үр дүнг дахаах хүснэгтэд үзүүлэв. Энэ арга нь төсөл хэрэгжих үед тухайн нөлөөлөл байгаа эсэх дээр тулгуурладаг ба хэрэв тухайн нөлөөлөл байвал “х” –ээр тэмдэглэдэг. Ингэхдээ тухайн нөлөөллийн хэлбэр, үргэлжлэх хугацаа, эрчим зэргийг тодруулах, мөн уг нөлөөлөл байгаль орчин, экологийн тэнцвэрт байдал, орон нутгийн нийгэм-эдийн засагт хэрхэн нөлөөлөл (шууд, шууд бус, эргэж нөлөөлөх, буцалтгүй нөлөөлөх, давхардах эсэх) байдлыг үзүүлдэг.

2.1.1 Шууд нөлөөлөл

Болзошгүй нөлөөллийн 13 (40.6%) нь шууд нөлөөлөлд хамрагдаж байна. Төслийн үйл ажиллагааны явцад хөрс, ургамлын бүтцийн өөрчлөлт, эвдрэл гарах, бэлчээр, агаар ба хөрсний бохирдол зэрэг нь шууд эерэгээр нөлөөлөхөөр байна.

2.1.2 Шууд бус нөлөөлөл

Нийт нөлөөллийн 4 (12.5%) нь шууд бус нөлөөлөлд хамрагдаж байна. Амьтдын орон зайн өөрчлөлт, гадаргын усны чанар, археологи, палеонтологийн олдворт шууд бус сөргөөр, үйлдвэр, үйлчилгээний салбарын үйл ажиллагаанд эерэгээр нөлөөлөхөөр байна.

2.2 Нөлөөллийн үргэлжлэх хугацаа

Төслийн үйл ажиллагаанаас нөлөөлөх эерэг ба сөрөг нөлөөллүүдийн дийлэнх нь урт хугацааны нөлөөлөлд хамрагдаж байна. Иймээс сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээг төлөвлөгөөний дагуу байнга тасралтгүй хийж байх шаардлагатай.

2.3 Нөлөөллийн эрчим

Төслийн сөрөг нөлөөлөл нь дундаас бага байгаа ба нийт 17 нөлөөллөөс 8 нь дунд зэрэг, 9 нь сул нөлөөлөл бөгөөд 11 нь сөрөг, 6 нь эерэг нөлөөлөл байна. Иймээс байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөг төслийн үйл ажиллагаатай холбож боловсруулан мөрдөж ажиллах шаардлагатай.

2.4 Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээ

Төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд нөлөөлж болзошгүй болон гол сөрөг нөлөөллийг тодорхойлоход төслийн явцад усны нөөц, горим, газрын гадарга, газрын хэвлий, хөрс, ургамал, агаар орчин бохирдох, хүний эрүүл мэнд зэрэгт сөргөөр нөлөөлөх магадлалтай тул төслийн сөрөг нөлөөг бууруулах, арилгах арга хэмжээний талаар зөвлөмж боловсруулсан болно.

2.5 Байгаль орчны менежментийн төлөвлөгөө

Төслийг хэрэгжүүлэх явцад БОННУ-ий тайлан, байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан болзошгүй болон гол сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ, тухайн орчинд төслийн үйл ажиллагаанаас шалтгаалан гарсан өөрчлөлтийг тодорхойлох, хянах зорилгоор зайлшгүй хянаж байх үзүүлэлтүүд, түүний тодорхойлолт, хуваарь, баримтлах стандарт, аргачлал, зардлыг тодорхойлон орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт тусгав.

ГУРАВ. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ

“ЭЛЕМЕНТ” ХХК нь хүний эрүүл мэнд болон Байгаль орчинд хор нөлөөгүй олонхын баримтлан ашиглаж байгаа зөвшөөрөгдсөн арга технологийг МУ-ын Хог хаягдлын хууль, Байгаль орчны холбогдох хуулиудад нийцүүлэн Монгол Улсын үндсэн хуулийн заалт болох Монгол Улсын иргэн эрүүл, аюулгүй орчинд амьдрах, ажиллах нөхцлийг хангахад бидний гол зорилт оршино. Үүний дагуу 2024 онд дараах 5 чиглэлээр төлөвлөж ажиллаж байна.

1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө
2. Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө
3. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө
4. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө
5. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

3.1 Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд нөлөөлж болзошгүй болон гол сөрөг нөлөөллийг тодорхойлоход төслийн явцад усны нөөц, горим, газрын гадарга, газрын хэвлий, хөрс, ургамал, агаар орчин бохирдох, хүний эрүүл мэнд зэрэгт сөргөөр нөлөөлөх магадлалтай тул төслийн сөрөг нөлөөг бууруулах, арилгах арга хэмжээний талаар дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр төлөвлөсөн. Үүнд:

Нийслэлийн Налайх дүүргийн 3-р хорооны нутагт орших “Элемент” ХХК-ийн
 “Аюултай хог хаягдал тээвэрлэх, цуглуулах, боловсруулах, устгах хими технологийн үйлдвэр”
 –ийн төслийн 2024 онд хэрэгжүүлэх Байгаль орчны менежментийн төлөвлөгөө

Хүснэгт 4. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний нийт зардал

№	Байгаль орчныг хамгаалах арга хэмжээ	Хамрах хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ /ш, жилээр/	Нэгжийн үнэлгээ, мян.төг	Нийт зардал, мян.төг	Хариуцагч
0	1	2	3	4	5	6	7
1	Эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлын нэгдсэн төвийн тээврийн хэрэгслийг үзлэг оношилгоонд жил бүр тогтмол хамруулах.	Агаар орчин	иж бүрэн	Дотоод зардал			БО-ны ажилтан
2	Мэдээллийн самбарт анхааруулга тавих	Агаар орчин	иж бүрэн	1	100.0	100.0	
3	Шатаах зуухны аюулгүй ажиллагааны дүрэм журам боловсруулах, дагаж мөрдөх	Агаар орчин	тогтмол	Үйл ажиллагааны зардал			
4	Агаарын бохирдлын эх үүсвэрийн дотоод хяналтын мэдээ тайланг мэргэжлийн хяналтын орон нутаг дахь салбарт гаргаж өгөх	Агаар орчин	тогтмол	Үйл ажиллагааны зардал			
Газрын гадрага, хөрсөн орчныг хамгаалах арга хэмжээ							
5	Зориулалтын цэгээс гадагш элдэв хог хаягдал хаяхгүй, газрын төрх, хөрсийг эвдэхгүй, хөндөхгүй байх арга хэмжээг хэвшүүлэх	Төслийн нийт талбайн хэмжээнд	удаа	Дотоод зардал			БО-ны ажилтан
6	Шатаах зуухнаас гарсан үнс болон хөөг зориулалтын дагуу ландфилл булшлах		Тогтмол	Дотоод зардал			
7	Хөрсөн орчны мониторинг судалгааг хийх		удаа	Дотоод зардал			
8	Эмнэлгийн хог хаягдал хүлээн авах хэсгийн газрыг хатуу хучилттай болгох, аюултай хог хаягдал асгарсан тохиолдолд хөрсөнд нэвчих боломжгүй байлгах		Тогтмол	Дотоод зардал			

Нийслэлийн Налайх дүүргийн 3-р хорооны нутагт орших “Элемент” ХХК-ийн
 “Аюултай хог хаягдал тээвэрлэх, цуглуулах, боловсруулах, устгах хими технологийн үйлдвэр”
 –ийн төслийн 2024 онд хэрэгжүүлэх Байгаль орчны менежментийн төлөвлөгөө

№	Байгаль орчныг хамгаалах арга хэмжээ	Хамрах хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ /ш, жилээр/	Нэгжийн үнэлгээ, мян.төг	Нийт зардал, мян.төг	Хариуцагч
9	Төлөвлөлтийн дагуу цаашид барилга байгууламж баригдахгүй болон үйл ажиллагаанд өртөөгүй талбайг доройтуулахгүйгээр хамгаалж, хөрсний элэгдэл, эвдрэл, бохирдолт үүсэхээс урьдчилан сэргийлэх		удаа	Дотоод зардал			
Усан орчныг амгаалах арга хэмжээ							
10	Ажлын байранд ариутгал халдваргүйжтэл хийх зөвлөмж	Эрүүл ахуй	4	Дотоод зардал			Эрүүл ахуйч эмч
11	Харьяалагдах сав газрын захиргаатай ус ашиглах гэрээ байгуулж, ус ашигласны төлбөр төлөх	Хаягдал бохир усны цооног	удаа	Дотоод зардал			
12	Газрын доорх усны мониторингийн хэмжилт хийх, багаж авах			1	18 000.0	18 000.0	
13	Ус хэмнэх технологи хэрэгжүүлэх /ариун цэврийн өрөөнд ус хэмнэдэг сантехникийн төхөөрөмжүүдийг суурилуулах/	Төслийн талбай	Иж бүрэн	Дотоод зардал			
14	Борооны ус хуримтлуулан дахин ашиглах зөвлөмж			Дотоод зардал			
15	Ус хангамжийн эх үүсвэрээс 50 метрээс доошгүй зайд эрүүл ахуйн хориглолтын бүс, 200 метрээс доошгүй зайд эрүүл ахуйн хязгаарлалтын бүсийг тогтоож мөрдөж ажиллах			Дотоод зардал			
16	70-80 хувь дүүрсэн үед бохирын цооногийг суллаж, цэг болон цэгийн орчинд халдваргүйжүүлэх үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгжээр халдваргүйжүүлэлтийг хийлгэнэ.	Төслийн талбай	Тухай бүр	Дотоод зардал			
Биологийн төрөл зүйлд үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ							

Нийслэлийн Налайх дүүргийн 3-р хорооны нутагт орших “Элемент” ХХК-ийн
 “Аюултай хог хаягдал тээвэрлэх, цуглуулах, боловсруулах, устгах хими технологийн үйлдвэр”
 –ийн төслийн 2024 онд хэрэгжүүлэх Байгаль орчны менежментийн төлөвлөгөө

№	Байгаль орчныг хамгаалах арга хэмжээ	Хамрах хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ /ш, жилээр/	Нэгжийн үнэлгээ, мян.төг	Нийт зардал, мян.төг	Хариуцагч
17	Эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлын нэгдсэн төвийн хашаан доторх сул чөлөөт талбайг тарималжуулж нөхөн сэргээх зөвлөмж	Төслийн талбай	удаа	Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөөнд зардал тусгагдсан			БО-ны ажилтан
18	Цахилгаан дамжуулах шугамын шувуунд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах ландфиллын талбайд шувуу үргээгч суулгах			4	150.0	600.0	
Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө							
19	Хог хаягдлыг ангилан, ялгах зориулалтын цэгийг тохижуулах	Төслийн нийт талбайн хэмжээнд	Иж бүрдэл	1 удаа	5 000.0	5 000.0	БО-ны ажилтан
20	Төслийн талбайд хог хаягдлыг ангилан ялгаж хаях боломжтой хогийн савыг байрлуулах, хаягжуулах			1 удаа	2 000.0	2 000.0	
21	Хог хаягдлын цэгт ариутгал, халдваргүйжүүлэлтийг тогтмол хийх, орчныг бохирдуулахаас сэргийлэх		Улирал д 1 удаа	4	50.0	200.0	Эрүүл ахуйч эмч
22	Хуванцар сав, шил, лааз гэх мэт хаягдлыг хоёрдогч түүхий эд авах цэгт тушаах	Төслийн нийт талбайн хэмжээнд	-	4	90.0	360.0	Аж, ахуйн нярав
23	Эзэмшил газрын ил задгай хаягдсан хогийг ангилан ялгаж цэвэрлэж байх	Төвийн ойр орчмын 100 метрт		Дотоод зардал			БО-ны ажилтан
24	Хог хаягдлыг бууруулах, ангилах, дахин ашиглах, зүй зохистой хаях дадал зуршлыг хэвшүүлэх сургалт хийх	Үйлдвэрийн ажилчдад		Дотоод зардал			
25	Шингэн хог хаягдал хадгалах зориулалтын цэгтэй болох			Дотоод зардал			

Нийслэлийн Налайх дүүргийн 3-р хорооны нутагт орших “Элемент” ХХК-ийн
 “Аюултай хог хаягдал тээвэрлэх, цуглуулах, боловсруулах, устгах хими технологийн үйлдвэр”
 –ийн төслийн 2024 онд хэрэгжүүлэх Байгаль орчны менежментийн төлөвлөгөө

№	Байгаль орчныг хамгаалах арга хэмжээ	Хамрах хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ /ш, жилээр/	Нэгжийн үнэлгээ, мян.төг	Нийт зардал, мян.төг	Хариуцагч
26	Үүсэх хог хаягдлын төрөл, кодыг ЗГ-ын 116 тогтоолд заасан хог хаягдлын кодчилсон жагсаалтын дагуу тогтоосон байх				Дотоод зардал		
27	Шатаах байгууламж бүхий үйлдвэрийн зуухны болон бойлерын үнсийг боловсруулах арга технологи нэвтрүүлэх	Хог хаягдлын нэгдсэн менежмент	Иж бүрэн	1	32 700.0	32 700.0	
Нийт зардал						58 960.0	

3.2 Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө

“Газрын тухай хууль”-ийн 56.6-р зүйл: Хот, тосгоны өнгө үзэмж, эрүүл ахуйн нөхцөлийг сайжруулах, газрыг хамгаалах, нөхөн сэргээх шаардлагын дагуу газар эзэмшигч нь эзэмшилд авсан газрын 10-аас доошгүй хувийг ногоон байгууламжтай байна. Төсөл хэрэгжүүлэгч нь ойролцоогоор 1999 м² талбайд ногоон байгууламжийг байгуулах шаардлагатай

Хүснэгт 5. Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө

№	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нийт зардал, төг /мян/	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Мод тарих	Төслийн талбайн хэмжээнд	ш	100	1 350.0	Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хууль MNS 4585:2016 Зүлэгжүүлэх талбай бэлтгэх, үр тарих, арчлах MNS 6260 : 2011
2	Зүлэгжүүлэх		м ²	100	1 350.0	
3	/Хар шороо, элс, бууц зэргийг бэлтгэнэ, бусад зардал/	Ажилчны хөлс	Ажилчин	2	1 565.0	

Нийслэлийн Налайх дүүргийн 3-р хорооны нутагт орших “Элемент” ХХК-ийн
 “Аюултай хог хаягдал тээвэрлэх, цуглуулах, боловсруулах, устгах хими технологийн үйлдвэр”
 –ийн төслийн 2024 онд хэрэгжүүлэх Байгаль орчны менежментийн төлөвлөгөө

Нийт зардал	4 265.0
--------------------	----------------

3.3 Эрсдлийн менежментийн төлөвлөгөө

Хүснэгт 6. Эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

№	Байгаль орчныг хамгаалах арга хэмжээ	Хамрах хүрээ	Хянах үзүүлэлт	Тоо хэмжээ	Нэгжийн үнэлгээ, мян.төг	Нийт зардал, мян.төг	Хариуцагч
1	2	3	4	5	6	7	8
1	Ажлын идэвхтэй талбайг тойруулан эрүүл ахуйн шаардлага хангасан гэрэлтүүлэг, гэрэл цацруулагч саад тавих	Төслийн талбай		1	1 000.0	1 000.0	
2	Ажилчдыг галын хор болон бусад хэрэгслийг ашиглаж сургах, дадлага эзэмшүүлэх зэрэг зохион байгуулалтын арга хэмжээг авах		Жил бүр	Үйл ажиллагааны хүрээнд			
3	Гал гарах зэрэг онцгой нөхцөлд хариу ажиллах бэлэн байдал (журам мөрдөх, ажилчдыг сургах, тоног төхөөрөмж, хэрэгсэл, хангамж),	Төслийн талбай	тогтмол	-	1 100.0	1 100.0	ХАБЭАА
4	Төслийн тухай мэдээллийн самбар, ажил эхлэх, дуусах хугацаа, холбоо барих хаяг, талбайн удирдах ажилтан, ачааны машинуудын явах зам, дэд төслийн зохион байгуулалт зэргийг мэдээлнэ.	Төслийн талбай	Иж бүрэн	1	600.0	600.0	
5	Цэвэрлэгээ, халдваргүйтгэлийг графикайн дагуу хийдэг, бүртгэл хөтөлдөг, дотоод хяналтын журам боловсруулж мөрдөх, хяналтын ажилтныг томилон ажлын байрны тодорхойлолтод ажил үүргийн хуваарийг нарийн тусгах	Төслийн талбайн эрүүл ахуйн хамгаалалтын бүс	Тогтмол	1	Дотоод зардал		Эрүүл ахуйч
6	Ажилчид ажлын байрны эрүүл мэнд, аюулгүй байдлын эрсдэл, аюулгүй байдлын дүрмийг хатуу мөрдөх талаар танилцуулна	Ажилчдад	Тогтмол	1	Дотоод зардал		
7	Ажиллагсдыг зориулалтын иж бүрэн хувцас хэрэгслээр хангах	Ажилчдад	Иж бүрэн	44 хүн	70.0	42 000.0	ХАБЭАА
8	Болзошгүй аюул ослын үед ашиглах бүрэн ажиллагаатай галын хор, багаж хэрэгслүүдийг бүх объектуудад байрлуулах, галын	Төслийн талбай	Тогтмол	Дотоод зардал			ХАБЭАА

Нийслэлийн Налайх дүүргийн 3-р хорооны нутагт орших “Элемент” ХХК-ийн
 “Аюултай хог хаягдал тээвэрлэх, цуглуулах, боловсруулах, устгах хими технологийн үйлдвэр”
 –ийн төслийн 2024 онд хэрэгжүүлэх Байгаль орчны менежментийн төлөвлөгөө

	аюулын үед ашиглах ослын гарцын зураглал хийж төвийн доторх хананд байршуулах					
9	Гал унтраах анхан шатны багаж хэрэгсэл болох лоом, хүрз, сүх, хөрөө, хувин, хоолой, багор дэгээ, жоотуу, тармуур, хөөс, хорны суурь, тэмдэг тэмдэглээ, сарай, элсний хайрцаг, шланг зэргийг бэлэн байлгах.	Төслийн талбай	Тогтмол	Дотоод зардал		
10	Ажилчдыг эрүүл мэндийн хугацаат үзлэг, шинжилгээнд хамруулах			44 хүн	1	3 520.0
11	Автоклавын халдваргүйжүүлэлтийн чанарыг хими, биологийн индикатораар тогтмол хянах. Химийн хяналтын өнгө хувиргагч цаасыг автоклавт хийж байгаа уут, сав нэг бүр дээр тус тус наана. Биологийн хяналтын индикаторыг улиралд 1 улаа автоклавт хийж хянана.			Дотоод зардал		
12	Автоклавын үйл ажиллагааг маягтын дагуу тогтмол хөтлөх.			Дотоод зардал		
Нийт зардал						48 220.0

3.4 Байгаль орчин- Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

“Элемент” ХХК-ийн “Эмнэлэгийн тусгай хог хаягдал цуглуулах, устгах үйлдвэр” төслийг хэрэгжүүлэх явцдаа үйл ажиллагааны улмаас байгаль орчинд сөрөг нөлөөлөл үзүүлж байгаагийн хувьд тус тайланд тусгагдсан зөвлөмжийг баримтлах нь зүйтэй.

Мөн компанийн удирдлагын тушаалаар байгаль орчны асуудал хариуцсан ажилтныг томилох буюу тухайн асуудлыг хэн нэгэн албан тушаалтанд хариуцуулж эзэнтэй болговол зохино.

Ингэснээр уг ажилтан байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө болон орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн хэрэгжилтийн асуудлаар компанийн захиргаа болон байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын өмнө хүлээх хариуцлагын орчин бүрдэнэ.

Нийслэлийн Налайх дүүргийн 3-р хорооны нутагт орших “Элемент” ХХК-ийн
 “Аюултай хог хаягдал тээвэрлэх, цуглуулах, боловсруулах, устгах хими технологийн үйлдвэр”
 –ийн төслийн 2024 онд хэрэгжүүлэх Байгаль орчны менежментийн төлөвлөгөө

Хүснэгт 7. Удирдлага зохион байгуулалтын
 төлөвлөгөөний нийт зардал

№	Байгаль орчныг хамгаалах арга хэмжээ	Хамрах хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн үнэлгээ, мян.төг	Нийт зардал, мян.төг	Хариуцагч
1	2	3	4	5	6	7	8
1	Байгаль орчныг хамгаалах ажлын жилийн тайлан, төлөвлөгөөгөө БОАЖЯ болон орон нутгийн засаг захиргаанд цаг тухайд нь гаргаж өгч байх		Байгаль орчныг хамгаалах ажлын жилийн тайлан, төлөвлөгөөгөө БОАЖЯ болон орон нутгийн засаг захиргаанд цаг тухайд нь гаргаж өгч байна. БОАЖС-ын А-618 тушаал	1	500.0	500.0	БО-ны ажилтан
2	Газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааг эрх бүхий мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлэх.		2024 онд авсан шинэ газар болон Багануур дүүрэг дэх газар	1	2 000.0	2 000.0	
3	Төсөл хэрэгжих орон нутгийн удирдлагатай нийгмийн хариуцлагын хүрээнд хамтран ажиллах		НД-ийн ЗДТГ-тай хамтран ажиллах гэрээ байгуулан ажиллах	Дотоод зардал			
4	Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 10 ¹ зүйлийн дагуу байгаль орчны аудитыг хийлгэх /2 жил тутамд/		Ерөнхий үнэлгээний дүгнэлтийн онцгойлон анхаарах зүйлд заасны дагуу тусгай зөвшөөрөлтэй мэргэжлийн байгууллагаар хийлгүүлэх.	Дотоод зардал			
Нийт зардал						2 500.0	

3.5 Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр /ОХШХ/ нь байгаль орчин, нийгэм эдийн засгийн үнэт зүйлийг хамгаалах, түүнд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах үйл ажиллагаа нь ямар үр дүнтэй байгааг илтгэх үндсэн баримт бичиг болно. ОХШХ-ийг жил бүр шинэчлэн боловсруулж, хяналт шинжилгээни дээж, сорьцыг МУ-ын болон гадаадын итгэмжлэгдсэн лабораториудад батлагдсан аргагүй, стандартын дагуу шинжлүүлэх тухайн оны эхэнд БОАЖЯ-аар батлуулж, оны эцэст тэдгээрийн биелэлтийг мөн БОАЖЯ болон УМХГ-т тайлагнана. Төслийн байгаль орчны нөлөөллийг тогтоохын тулд дараах хоёр бүсэд ОХШХ-ийг хэрэгжүүлнэ. Үүнд:

1. Нөлөөллийн цөм бүс
2. Нөлөөлөлд өртөгч бүс

Нөлөөллийн цөм бүс нь тухайн төслийн хэрэгжилт, хамрах талбайн хил заагаар хязгаарлагдана. Энэ хэсэгт ОХШХ-т туссан байгалийн объект бүрээс дээж авах ба нөлөөлөлд өртөгч бүс нь хамрагдах газрын заагаас гадагш бүх зүгт жигд тархалттай байх тул тус төслийн хувьд хамгийн ихдээ 1.0км байхаар тооцлоо. Энэ бүсэд ОХШХ-т туссан байгалийн объект бүрээс дээж авах шаардлагагүй ба тухайн төслийн онцлог, байгаль цаг уурын нөхцлөөс хамаарч 1 болон түүнээс олон тооны хяналтын цэг тогтоогдох боломжтой. Хяналтын цэгүүдийг сонгохдоо тухайн байгалийн бүрэлдэхүүн хэсэг тус бүрийн онцлог, шилжилт хөдөлгөөн, төслийн нөлөөлөл, эрчим зэрэг хүчин зүйлийг харгалзана. ОХШХ-ийг хэрэгжүүлэхдээ хяналтын цэгүүдэд заагдсан хугацаанд мэргэжлийн байгууллагаар хийлгэх ба хяналтын цэгүүдийн байршлыг өөрчлөх боломжтой.

Хүснэгт 8. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн нийт зардал

№	Хяналтын цэгийн байршил	Хугацаа давтамж	Давтам жийн тоо	Нийт зардал, мян.төг	Хууль, бодлого, стандарт
0	1	2	3	4	5
Агаарын чанар					
1	- Аюултай хог хаягдал шатаах зуухны барилга дотор -1 цэг 47°46'3.38"N 107°17'59.91"E - Оффис дотор-1 цэг 47°46'3.33"N 107°18'3.64"E Төслийн талбайн хашаан дотор-1 цэг 47°46'1.87"N 107°18'8.28"E	Улирал бүр	5 цэгт	456.8	/CO ₂ , NO ₂ , SO ₂ , Нийт тоос, Дуу шуугиан хэмжээ / MNS 6342 : 2012 Агаарын чанар. Аюултай хог хаягдал шатаах зуухны яндангаар агаар мандалд хаягдах утааны найрлага дахь агаар бохирдуулах

*Нийслэлийн Налайх дүүргийн 3-р хорооны нутагт орших “Элемент” ХХК-ийн
“Аюултай хог хаягдал тээвэрлэх, цуглуулах, боловсруулах, устгах хими технологийн үйлдвэр”
-ийн төслийн 2024 онд хэрэгжүүлэх Байгаль орчны менежментийн төлөвлөгөө*

№	Хяналтын цэгийн байршил	Хугацаа давтамж	Давтамжийн тоо	Нийт зардал, мян.төг	Хууль, бодлого, стандарт
0	1	2	3	4	5
	ЭХХ шатаах зуухны барилга дотор-1 цэг - 47°46'1.64"N 107°18'5.59"E - Хлорын байгууламж дотор -1 цэг				зарим бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ
2	Хаягдал угааны хэмжилт хийлгэх (O ₂ , CO ₂ , CO, SO ₂ , NO _x , тоос/дэгдэмхий үнс/)	Жилд нэг удаа	2 цэгт	389.0	
Хөрс					
3	- Төслийн талбай дотор-5 цэг 47°46'2.64"N 107°18'1.79"E 47°46'1.58"N 107°18'1.73"E 47°46'0.53"N 107°18'2.28"E 47°46'3.09"N 107°18'5.34"E 47°46'4.14"N 107°18'8.08"E Хөрсний хүнд металлууд (Ni, Cd, Pb, Cu, Zn, Cr)	Улирал бүр	3 цэгт	336.0	MNS 3297-2019 Байгаль хамгаалал. Хөрс. Хот, суурин газрын хөрсний ариун цэврийн үнэлгээний үзүүлэлтийн норм, хэмжээ стандарт Хөрсний чанар. Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ MNS 5850: 2019
4	- Аюултай хог хаягдал шатаах зуухны үнс-1 цэг 47°46'3.47"N 107°18'0.82"E - ЭХХ шатаах зуухны үнс-1 цэг - 47°46'1.54"N 107°18'5.08"E	Жилд 1 у	2 цэгт	320.0	
Усны чанар					
5	- Гүний худаг болон мониторингийн цооногт	Улирал бүр	1 цэгт	83.0	- MNS 0900:2018 Хүрээлэн буй орчин. Эрүүл мэндийг хамгаалах. Аюулгүй байдал. Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ
6	- Гүний худаг болон мониторингийн цооногт /мониторгийн цооногт ус илэрсэн тохиолдолд шинжилгээнд хамруулна/	Улирал бүр	4 цэгт	256.0	- MNS 4943:2015 Хүрээлэн байгаа орчин. Усны чанар. Хаягдал ус. Ерөнхий шаардлага
7	- Бохир усны хяналт шинжилгээ	Улирал бүр	1	480.0	- MNS 6561:2015 Хүрээлэн байгаа орчин. Усны чанар. Ариутгах татуургын сүлжээнд нийлүүлэх хаягдал ус. Ерөнхий шаардлага
Нийт дүн				2 320.8	

3.6 Байгаль орчны менежмент төлөвлөгөө ба түүний хэрэгжилтийг оролцогч, сонирхогч талуудад тайлагнах, хэлэлцүүлэх хуваарь.

Хүснэгт 9. БОМТөлөвлөгөөг тайлагнах хуваарь

№	БОМТ, түүний хэрэгжилтийг тайлагнах, хэлэлцүүлэх байгууллагууд	Тайлагнах, хэлэлцүүлэх арга хэлбэр	Мэдээний агуулга	Хугацааны тов	Хэлэлцүүлгээр санал авах чиглэл	Зохион байгуулах газар
0	1	2	3	4	5	6
1	Төрийн захиргааны төв байгууллага	БОМТ-н жилийн төлөвлөгөө	БОННУ-р тодорхойлсон сөрөг нөлөөллийг бууруулах, зөвлөмж, батлагдсан БОМТ-нд үндэслэн тухайн жилийн төлөвлөгөө боловсруулах	Жил бүр Эхний улиралд	Төлөвлөгөө батлуулах	БОАЖЯ
2	Нийслэлийн Байгаль орчны газарт	БОМТ-н жилийн тайлан	Төлөвлөгөөний хэрэгжилт, ОХШХ-н хэрэгжилт	Жил бүр 11-р сарын 1-ний дотор	Тайлан хянуулах	БОАЖЯ, НБОГ
3	БОАЖЯ-ийн сайдын 2019 оны А/618 тоот тушаалын 4.3-т заасны дагуу ажлын хэсгийг тухайн аймаг, нийслэлийн ЗД-ын захирамжаар байгуулна.	БОМТ-н жилийн төлөвлөгөө, тайлан	Тухайн жилийн БОМТ-ний хэрэгжилтийн талаар	Жил бүр 11-р сарын 30-ний дотор	Тайлан хянуулах, дүгнүүлэх (хяналтын хуудас авах)	Аймаг, нийслэлийн ЗД-ын захирамж
4	Багийн ИНХ (нөлөөллийн бүсэд оршин суугч)	Танилцуулга, илтгэл болон мэдээлэл өгч хурлаар хэлэлцүүлэх	БОМТ-ний хэрэгжилтийн явцыг БО-ны бүрдэл хэсгүүдээр гарган танилцуулах	Жилд 1 удаа	БО-ны хэлтэс, Орон нутагтай харилцах ажилтан	Орон нутгийн ЗДТГ болон төслийн талбайд
Нийт дүн				-		

3.7 Байгаль орчны менежмент төлөвлөгөөнд тусгагдсан нийт зардал

Хүснэгт 10. 2024 онд байгаль орчин хамгаалах чиглэлээр хийгдэх ажлын нийт зардал

№	Үзүүлэлтийн нэр	Зардлын төрөл, чиглэл	Зардалын хэмжээ (мян.төг)
1	2	3	4
1	Байгаль хамгаалах төлөвлөгөө	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	18 700.0
		Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	2 320.8
		Орчны тохижилт, нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	4 265.0
		Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	48 220.0
		Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	40 260.0
		Дүйцүүлэн хамгаалах	-
2	Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	2 320.8
Нийт зардал, мян.төг			116 085.8